



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/315

Чингис хот

ЗӨВЛӨЛ ШИНЭЧЛЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "а", 29.3, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах зөвлөлийг шинэчлэн доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл ашиглалт хяналтын мэргэжилтэн
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн дарга

2. "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогд дулан аймгийн Засаг даргын 2020 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн А/366 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011684